

Аудитын код: САГ-2018/100/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
“Ньюбаланс Аудит” ХХК
Утас: 70145542 Цахим хаяг: newbalance_audit@yahoo.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Орлого, зардал, төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Авлагын бүртгэлийн талаар.....	4
2.9.2	Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
3	Менежментийн захидал	7
3.1	Авлагын бүртгэлийн талаар.....	8
3.2	Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	11
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.14 № 06/673
танай _____ -ны № _____ -т

“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.БАТЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2018\0314SAG12.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
875548
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Үндэсний дата төв” УТҮГ-ын захирал Б.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах, үндсэн хөрөнгө бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн болон бусад эрх зүйн шийдвэрийн холбогдох заалтыг мөрдөх тухай зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг хэрэгжүүлж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Үндэсний дата төв” газартай байгуулсан гэрээний дагуу “Ньюбаланс Аудит” ХХК-ийн аудитор Д.Гэрэлчулуун, аудиторовын туслах Л.Наранбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв. САГ-2018/100/СТА-ТӨҮГ



Аудитаар “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01/32 дугаар албан бичгээр “Ньюбаланс Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

“Үндэсний дата төв” УТҮГ нь төрийн байгууллагуудын цахим хуудас байршуулах, төрийн үйлчилгээний “ТҮЦ” машины ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллах үйл ажиллагааг тогтвортой, найдвартай, тасралтгүй хэрэгжүүлж, Монгол Улсын Үндэсний цахим дата, мэдээллийн нэгдмэл, шуурхай, хүртээмжтэй байдлыг хангаж, Төрөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлж байгаа төрийн цахим үйлчилгээг хариуцан ажилладаг байна. Тайлант 2017 онд тус байгууллага үндсэн үйл ажиллагааны чиглэлээр дараах арга хэжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2015-2027 оны мастер төлөвлөгөө, 2017-2020 оны хөгжлийн хөтөлбөр, 2016-2018 оны стратеги төлөвлөгөө зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраар батлуулсан байна.
- Байгууллагын хэмжээнд цахим оффисын системийг цахим гарын үсгийн хамт үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн байна.
- CentOS, Ubuntu болон Archlinux системүүдийн толин серверүүдийг шинэчлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлжээ.
- Цахим мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголт мэдээллийг олон нийтэд хүргэх, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, авах арга хэмжээг тодорхойлох чиглэлээр уулзалт өдөрлөг, хурал семинар, тэмцээн уралдааныг шат дараатай зохион байгуулсан байна.


“Үндэсний дата төв” УТҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, 2017 оны 361 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тус байгууллага нь улсын төсөв болон өөрсдийн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг байна.

“Үндэсний дата төв” УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн төрийн аудитын байгууллага болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.



Аудитаар “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 19 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Үндэсний дата төв” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Үндэсний дата төв” УТҮГ нь Ординат компанийн нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програмыг санхүүгийн үйл ажиллагаандаа 2014 оноос хойш нэвтрүүлэн ашигласан байна. Програмын шинэчлэл тухай бүр хийгдэж, бүртгэл тооцоо, мэдээллийг хоцрогдол, алдаагүй боловсруулж байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Үндэсний дата төв” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.


Хөдөлмөрийн дотоод журам, дотоод хяналтын журам, албан тушаалын тодорхойлолтын хүрээнд байгууллагын дотоод хяналтыг Захиргаа, Бизнес шинжилгээний хэлтсийн Бизнес төлөвлөлт, хяналт шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд төвийн захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Санхүүгийн хяналт,
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хяналт,
- Аюулгүй байдлын хяналт,
- Үйлчилгээний чанарын хяналт,
- Иргэд, ажилтны мэдээллийн мөрөөр хийгдэх хяналт,
- Ажилтнуудын ажил, тэдгээрийн гүйцэтгэлд албаны шалгалт хийх зэрэг арга замуудаар хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлага нь байгууллагын үйл ажиллагаа, төсөв, хөрөнгө, ажилтнуудын үйл ажиллагааны талаар байнгын мэдээлэл гаргуулж, 7 хоног бүр шуурхай хурал хийж, асуудлуудыг хянаж тухай бүр шийдвэрлэн ажилладаг байна.

2.6 Орлого, зардал, төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсаны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ төсвөөс урсгал зардалд 2,600.8 сая төгрөгийн санхүүжилт авахаас бүрэн авч зарцуулсан байна.



Мөн үндсэн үйл ажиллагаанаас 209.1 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 1,789.9 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Ажиллагсдын цалинд 1,190.6 сая, НДШ-ийн зардалд 131.0 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 440.7 сая, хангамж бараа материалын зардалд 211.7 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 300.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр /Мэдээлэл, технологийн үйлчилгээ-1,387.4 сая төгрөг/-т 1,637.8 сая, урсгал шилжүүлэгт 639.9 сая, бусад зардалд 43.8 сая, нийт 4,595.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

“Үндэсний дата төв” УТҮГ нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр мэдээллийг оруулсан байна. Байгууллагын www.datacenter.gov.mn цахим хуудсанд шилэн дансны цэсийг холбосон бөгөөд шилэн дансны www.shilendans.gov.mn цахим санд байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан зарлагын гүйлгээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг оруулжээ. Тайлант онд Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитад хамрагдсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл


2.9.1 Авлагын бүртгэлийн талаар

Тайлант хугацааны эцэст 33.3 сая төгрөгийн авлагатай байгаагаас төлбөрт үйлчилгээний авлага 3.0 сая төгрөг, байгууллагаас авах авлага 30.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс “УБЦТС” ТӨХК-иас авах 0.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацааны эцэс дэх авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай бүрэн тооцоо нийлж баталгаажуулах, авлага барагдуулж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.9.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

- 2016 оны 4 дүгээр сард ашиглалтад орсон 4.5 сая төгрөгийн санхүү үнэтэй 25 ширхэг гадна орчны хяналтын камерын ашиглах хугацаа бүртгэлд



тусгаагүйгээс шалтгаалан тайлант онд 1.1 сая төгрөгийн элэгдлийг тооцолгүй орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь заалтыг үндэслэн дутуу байгуулсан хөрөнгийн элэгдлийг аудитын явцад залруулсан.

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохих зөвшөөрөл авалгүйгээр 40.3 сая төгрөгийн үнэ бүхий “ТҮЦ” машины мониторингийн дэлгэц, Epson L565 өнгөт принтерийг худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төрийн өмчид эд хөрөнгийг дараахь хэлбэрээр олж авна”, 6.1.3-т “эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах талаар Менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 41.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад 1.1 сая төгрөгийн бүртгэлийн алдааг залруулж, санхүүгийн тайланг өөрчлөн бэлтгүүлсэн бөгөөд 40.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд эдгээр зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 5,587.2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувиар буюу 55.9 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Үндэсний дата төв” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад зөвчилж, санал дүгнэлт өгсөн.

тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2018 оны 3 дугаар сар



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Үндэсний дата төв” УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Авлагын бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант хугацааны эцэст 33.3 сая төгрөгийн авлагатай байгаагаас төлбөрт үйлчилгээний авлага 3.0 сая төгрөг, байгууллагаас авах авлага 30.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс “УБЦТС” ТӨХК-иас авах 0.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөх, санхүүгийн тайлангийн “үнэн зөв”, “эрх үүрэг” батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Тайлант хугацааны эцэс дэх авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай бүрэн тооцоо нийлж баталгаажуулах, авлага барагдуулж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж зөвшөөрүүлсэн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохих зөвшөөрөл авалгүйгээр 40.3 сая төгрөгийн үнэ бүхий “ТҮЦ” машины мониторингийн дэлгэц, Epson L565 өнгөт принтерийг худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төрийн өмчид эд хөрөнгийг дараахь хэлбэрээр олж авна”, 6.1.3-т “эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хуулийн заалт зөрчигдөх, санхүүгийн тайлангийн “үнэн зөв”, “эрх үүрэг”, “тохиолдсон байх” батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Хөрөнгө бэлтгэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж зөвшөөрүүлсэн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/


Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	227,701,099.25	212,162,860.95
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	8,224,460.00	12,189,500.00
Касс	-	-
Арилжааны банк дахь харилцах	414,500.00	2,504,500.00
Замд яваа хадгаламж	7,809,960.00	9,685,000.00
АВЛАГА	6,630,600.00	33,306,078.97
Төлбөртэй үйлчилгээний авлага	6,630,600.00	3,049,000.00
Бусад авлага		
Байгууллагаас авах авлага	-	30,257,078.97
БАРАА МАТЕРИАЛ	212,846,039.25	166,667,281.98
Бичиг хэргийн материал	5,303,190.67	35,651,054.79
Аж ахуйн материал	16,991,349.00	19,041,239.00
Сэлбэг хэрэгсэл	174,989,339.58	103,525,587.19
Түлш,шатах тослох материал	15,562,160.00	8,449,401.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,985,213,861.39	4,580,131,096.66
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,985,213,861.39	4,580,131,096.66
Биет хөрөнгө	5,416,896,504.29	4,323,505,257.12
Барилга,байгууламж,орон сууц	2,143,735,807.00	2,143,735,807.00
Хуримтлагдсан элэгдэл	215,063,580.48	250,907,510.52
Авто-тээврийн хэрэгсэл	49,500,000.00	-
Хуримтлагдсан элэгдэл	49,500,000.00	-
Машин,тоног төхөөрөмж (компьютер)	13,211,037,923.69	13,072,428,133.07
Хуримтлагдсан элэгдэл	9,776,958,841.15	10,683,176,340.52
Тавилга, аж ахуйн эд хогшил	141,196,159.71	126,914,431.71
Хуримтлагдсан элэгдэл	87,127,964.48	85,566,263.62
Ном	77,000.00	77,000.00
Биет бус хөрөнгө	568,317,357.10	256,625,839.54
Програм хангамж	1,742,649,511.01	1,748,818,811.01
Хуримтлагдсан элэгдэл	1,174,332,153.91	1,492,192,971.47
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,212,914,960.64	4,792,293,957.61
НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,435,451.11	10,016.38
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,435,451.11	10,016.38
Өглөг	15,435,451.11	10,016.38
ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	6,197,479,509.53	4,792,283,941.23
Засгийн газрын оруулсан капитал	6,714,633,065.33	6,714,633,065.33
Хуримтлагдсан үр дүн	(517,153,555.80)	(1,922,349,124.10)
Өмнөх үеийн үр дүн	(517,153,555.80)	(517,153,555.80)
Тайлант үеийн үр дүн	-	(1,405,195,568.30)
НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,212,914,960.64	4,792,293,957.61

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,935,692,797.02	4,182,072,420.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,320,225,251.53	1,581,274,120.00
Нийтлэг татварын бус орлого	1,320,225,251.53	1,581,274,120.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,320,225,251.53	1,581,274,120.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	228,332,806.98	205,546,900.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,091,525,444.55	1,375,727,220.00
Бусад орлого	367,000.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,615,467,545.49	2,600,798,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1,615,467,545.49	2,600,798,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,615,467,545.49	2,600,798,300.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,644,476,718.24	5,587,267,988.30
УРСГАЛ ЗАРДАЛ	5,644,476,718.24	5,587,267,988.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,644,476,718.24	5,395,467,035.46
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,203,734,703.19	1,211,057,510.81
Үндсэн цалин	923,542,769.86	906,078,974.65
Унаа хоолны хөнгөлөлт	33,012,000.00	32,814,000.00
Гэрээт ажлын хөлс	247,179,933.33	272,164,536.16
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,513,161.51	130,143,195.38
Тэтгэврийн даатгал	128,513,161.51	130,143,195.38
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	388,836,721.27	388,666,289.67
Гэрэл, цахилгаан	252,885,546.43	265,918,766.76
Түлш, халаалт	63,787,609.06	53,149,160.00
Цэвэр, бохир ус	3,460,440.62	6,713,712.91
Байрны түрээс	68,703,125.16	62,884,650.00
Хангамж, бараа материалын зардал	304,292,547.52	330,522,362.39
Бичиг хэрэг	174,341,533.28	225,149,398.29
Тээвэр, шатахуун	91,439,170.00	66,537,000.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	31,798,770.24	37,220,544.10
Аж ахуйн материал худалдан авах зардал	6,713,074.00	1,615,420.00
Эд хогшил, урсгал засварын зардал	351,413,928.73	365,633,022.98
Урсгал засвар	351,413,928.73	365,633,022.98
Томилолт, зочны зардал	15,955,000.00	21,728,022.00
Гадаад албан томилолт	5,200,000.00	10,852,872.00
Дотоод албан томилолт	10,755,000.00	10,875,150.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	550,575,594.88	575,981,957.50
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,230,276.00	95,922,624.00



Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,500,000.00	3,960,000.00
Даатгалын үйлчилгээ	-	953,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,085,640.00	65,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	468,120,245.88	467,672,278.50
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,639,433.00	7,408,655.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,701,155,061.14	2,371,734,674.73
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,847,500.00	22,105,035.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,671,307,561.14	2,349,629,639.73
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	191,800,952.84
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	191,800,952.84
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	191,800,952.84
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(2,708,783,921.22)	(1,405,195,568.30)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(2,708,783,921.22)	(1,405,195,568.30)



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн				
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33		(517,153,555.80)	6,197,479,509.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн			(1,405,195,568.30)	(1,405,195,568.30)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33		(1,922,349,124.10)	4,792,283,941.23



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,417,556,271.53	4,599,788,917.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,654,880,371.53	1,998,990,617.00
Нийтлэг татварын бус орлого	1,654,880,371.53	1,998,990,617.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,654,880,371.53	1,998,990,617.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	231,817,306.98	209,128,500.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,416,864,064.55	1,789,862,117.00
Бусад орлого	6,199,000.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,762,675,900.00	2,600,798,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1,762,675,900.00	2,600,798,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,762,675,900.00	2,600,798,300.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,409,364,811.53	4,595,823,877.00
УРСГАЛ ЗАРДАЛ	3,409,364,811.53	4,595,823,877.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,409,364,811.53	4,595,823,877.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,201,553,092.07	1,190,588,000.00
Үндсэн цалин	905,361,299.52	896,133,600.00
Унаа хоолны хөнгөлөлт	29,523,000.00	29,402,000.00
Гэрээт ажлын хөлс	266,668,792.55	265,052,400.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,337,257.67	130,964,900.00
Тэтгэврийн даатгал	131,337,257.67	130,964,900.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	367,969,625.16	440,697,273.67
Гэрэл, цахилгаан	242,161,750.32	276,617,561.76
Түлш, халаалт	51,793,039.06	93,481,349.00
Цэвэр, бохир ус	3,756,710.62	6,713,712.91
Байрны түрээс	70,258,125.16	63,884,650.00
Хангамж, бараа материалын зардал	268,945,555.24	211,724,878.11
Бичиг хэрэг	141,079,876.00	107,157,300.00
Тээвэр, шатахуун	94,094,400.00	62,706,600.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	28,581,380.24	37,293,988.11
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	722,852.00	803,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,467,047.00	3,763,990.00
Эд хогшил, урсгал засварын зардал	303,302,913.00	300,282,804.99
Багаж, техник, хэрэгсэл	35,021,660.00	11,541,070.99
Тавилга	3,549,700.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,013,000.00	5,146,820.00
Урсгал засвар	262,718,553.00	283,594,914.00
Томилолт, зочны зардал	15,955,000.00	16,039,150.00
Гадаад албан томилолт	5,200,000.00	5,164,000.00
Дотоод албан томилолт	10,755,000.00	10,875,150.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	622,228,113.88	1,637,779,067.50
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,775,958.00	95,638,825.00

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,500,000.00	3,960,000.00
Даатгалын үйлчилгээ	900,000.00	891,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	185,640.00	127,400.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	513,579,591.88	1,387,434,013.50
Газрын төлбөр	1,667,424.00	833,712.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	619,500.00	4,444,940.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	144,449,177.00
Бараа үйлчилгээний бусад зардал	29,847,500.00	27,793,907.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,847,500.00	27,793,907.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	468,225,754.51	639,953,895.73
Бусад урсгал шилжүүлэг	-	19,681,342.89
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	19,681,342.89
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	468,225,754.51	620,272,552.84
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	147,208,354.51	86,471,952.84
Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	321,017,400.00	533,800,600.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,191,460.00	3,965,040.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	8,191,460.00	3,965,040.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,000.00	8,224,460.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,224,460.00	12,189,500.00



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I Орлогын дүн	2,600,798,300.00	2,600,798,300.00
Төсвөөс урсгал санхүүжилт	2,600,798,300.00	2,600,798,300.00
Төсөл арга хэмжээний зардал		
Эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт		
Үйл ажиллагааны орлогоос		
Үйл ажиллагааны бус орлогоос		
Ангилалдаагүй орлого		
II Нийт зарлагын дүн	2,600,798,300.00	2,600,798,300.00
A.Урсгал зардлын дүн	2,600,798,300.00	2,408,997,347.16
1.Бараа үйлчилгээний зардал	2,510,312,300.00	2,389,316,004.27
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	925,535,600.00	925,535,600.00
Үндсэн цалин	889,860,000.00	896,133,600.00
Хоол унааны зардал	35,675,600.00	29,402,000.00
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалын төлөх шимтгэл	101,809,100.00	101,809,100.00
Тэтгэвэр тэтгэмжийн даатгалын шимтгэл	72,191,960.80	72,191,960.80
Тэтгэвэрийн шимтгэл	64,787,676.00	64,787,676.00
Тэтгэмжийн даатгал	7,404,284.80	7,404,284.80
ҮОМШ өвчний даатгал	9,255,356.00	9,255,356.00
Ажилгүйдлийн даатгал	1,851,071.20	1,851,071.20
Байгууллага төлөх ЭМД	18,510,712.00	18,510,712.00
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	1,482,967,600.00	1,296,031,304.27
Байр ашиглалттай холбоотой зардал	446,076,500.00	398,533,823.67
Гэрэл цахилгаан	297,000,000.00	276,617,561.76
Түлш халаалт	112,860,000.00	93,481,349.00
Цэвэр бохир ус	8,972,100.00	6,713,712.91
Байрны түрээсийн хөлс	27,244,400.00	21,721,200.00
Хангамж бараа материал	34,797,700.00	31,267,568.54
Бичиг хэрэг	6,496,400.00	6,389,360.00
Тээвэр шатахуун	16,724,800.00	16,724,700.00
Шуудан холбоо	7,108,200.00	3,586,518.54
Хог хаягдал устгах,цэвэрлэх	530,100.00	803,000.00
БҮТЭЗ	3,938,200.00	3,763,990.00
Эд хогшил,урсгал засварын зардал	46,250,900.00	46,110,400.00
Багаж хэрэгсэл	2,692,800.00	4,119,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,138,400.00	4,366,820.00
Урсгал засвар	41,419,700.00	37,624,580.00
Томилолт зочны зардал	5,164,000.00	5,164,000.00
Гадаад албан томилолт		5,164,000.00
Дотоод албан томилолт	2,159,800.00	
Гадаад зочны зардал	3,004,200.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	921,057,700.00	787,161,695.06
Аудитын үйлчилгээний	3,960,000.00	3,960,000.00
Даатгалын үйлчилгээ	891,000.00	891,000.00

Тээврийн хэрэгсэлийн оношлогоо	207,900.00	127,400.00
Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	663,152,800.00	632,455,376.06
Газрын төлбөр	990,000.00	833,712.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,752,000.00	4,444,940.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх	176,418,000.00	144,449,177.00
Бараа үйлчилгээний бусад зардал	29,620,800.00	27,793,907.00
Хичээл үйлдвэрлэл	29,620,800.00	27,793,907.00
Холбооны суваг ашигласны төлбөр	70,686,000.00	65,940,000.00
Холбооны суваг ашигласны	70,686,000.00	65,940,000.00
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	19,800,000.00	19,681,342.89
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	19,800,000.00	19,681,342.89
Нийгмийн хамгаалал,	-	
Бусад урсгал шилжүүлэг /нэр данс зөрүү, даатгал/		-
Орлого бууруулах /Нийслэлийн тээвэр ЭМНДГ ЦЕГМТТ/		
Төвлөрүүлэн шилжүүлэг /Улсын төсөв/	-	191,800,952.84
III. Байгууллагын тоо	1	1
Ажиллагсад бүгд	66	66
Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	45	45
Үйлчлэх ажилтан	5	5
Гэрээт ажилтан	15	15

